



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 586

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2, 6.3.4, 6.4.3, 6.4.4, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 9,646,090.00 (есөн сая зургаан зуун дөчин зургаан мянга ерэн) төгрөгийн балансын үнэ, хуриимтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Р.Дагдан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан тайлагнах.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.Дугаар

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн
371 дугаар тогтоолын хавсралт

"УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН
БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон огноо	Балансын үнэ, хуимтлагдсан элэгдэл	ТӨБЗГ-ЫН 2020 ОНЫ 520 дугаар тогтоолоор тогтоосон худалдах доод үнэ	ТӨБЗГ-ЫН 2021 ОНЫ 371 дүгээр тогтоолоор тогтоосон худалдах доод үнэ
				(төгрөг)	
1	Тоёота камри, 76-58 УБӨ, SXV200327510	2012/03/01	9,646,090.00	500,000.00	300,000.00
			9,646,090.00	500,000.00	300,000.00
	Нийт дүн		(есөн сая зургаан зуун дөчин зургаан мянга ерэн)	(таван зуун мянган)	(гурван зуун мянган)